ҮННТ АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ТӨГӨЛ-ИНВЕСТ ББСБ ХХК-ИЙН 2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ТАСАЛБАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ



УЛААНБААТАР ХОТ
2025

АГУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ
УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Компанийн оноосон нэр		Тус компанийн дүрэмд компанийн оноосон нэрийг “Төгөл-Инвест ББСБ” ХХК гэсэн байна.
Үүсгэн байгуулах шийдвэр		Үүсгэн байгуулагчийн 2011 оны 03 сарын 28-ны өдрийн 93 дугаар шийдвэрээр үүсэн байгуулагдсан.
Улсын бүртгэлийн гэрчилгээ		Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газар 2011 оны 05 сарын 02-ны өдөр бүртгэж, 9015002030 дугаар бүхий Улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгосон байна.
Регистрийн дугаар		5443261
Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх Үйл ажиллагааны чиглэл		659200 - Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа
Тусгай зөвшөөрөл		Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 03 сарын 28-ны өдрийн 93-р тогтоол ТЗ 101/220 дугаартай “Банк бус санхүүгийн” үйл ажиллагаа эрхлэх болон 2023 оны 09 сарын 01-ны өдрийн 433-р тогтоолоор “Гадаад валютын арилжаа” эрхлэх тусгай зөвшөөрлийг авсан.
Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн тоо		Гишүүдийн тоо 1
Өмчийн хэлбэр		Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Өөрийн хөрөнгийн хэмжээ		Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх өөрийн хөрөнгийн хэмжээ 2,515,240.0 мянган төгрөг
Хуулийн этгээдийн албан ёсны хаяг		Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Таван богд плаза-221 тоот
Холбоо барих утас		88101066

ТӨГӨЛ-ИНВЕСТ ББСБ

Огноо:2025.01.30 25/2025 Улаанбаатар хот

“ ҮННТ ” АУДИТ ХХК-д

Удирдлагын хариуцлагын захидал

“Төгөл-Инвест ББСБ” ХХК-ийн удирдлага бид санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй. Бид эдгээр санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”), Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэж дараах баталгааг гаргаж байна.

Үүнд: Нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд чухал үүрэг гүйцэтгэдэг удирдлага болон ажилтангууд санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх зөрчилтэй зүйлд оролцоогүй; Бид та бүхэнд бүх данс бүртгэлийн дэвтрүүд, туслах нотлох баримт бичгүүд болон хувьцаа эзэмшигчид, ТУЗ- ийн хурлын бүх тогтоол, шийдвэр протоколыг гаргаж өгсөн; Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг СТОУС-ын дагуу үнэн зөв тусгасан; Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн; Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан; Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй; Залилангийн улмаас санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай тайлагнагдах эрсдлийн талаар бидний хийсэн үнэлгээний үр дүнг бид танд тодруулж өгсөн; Бид байгууллагад нөлөө үзүүлэх удирдлага болон дотоод хяналтанд чухал үүрэг гүйцэтгэдэг ажилтнуудыг хамарсан залилан болон залилан байж болзошгүй асуудалтай холбоотой бүх мэдээллийг тодруулж өгсөн; Бид залилан гэж зарлагдсан болон сэжиглэгдсэн асуудлуудын талаар ажиллагсад, хуучин ажиллагсад, шинжээчид, зохицуулагчид болон бусад этгээдүүийн мэдээлсэн, санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх бүх мэдээллийг танд тодруулж өгсөн; Бид санхүүгийн тайланг бэлдэхэд үр нөлөөг тооцох ёстой хууль журам зөрчсөн байж болзошгүй, өөрсдийн мэдэж буй бүх тохиолдолуудыг танд тодруулж өгсөн; Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Гүйцэтгэх захирал:

ТӨГӨЛ-ИНВЕСТ
Ж.БАЯРМАА
ТТГ5577 5443261

Ерөнхий нягтлан бодогч:

ТӨГӨЛ-ИНВЕСТ
Т.БЯМБАА
ТТГ5577 5443261

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
3-р хороо, үйлдвэр 29, 83 тоот

Утас: 88220399, 70110918
Имэйл: info.tugulinvest@gmail.com

ҮННТ АУДИТ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
17-р хороо, Ворлд Монголиа Тауэр, 615 тоот
Утас: 976-99183655, 976-80183655
И-мэйл: info@unnt-audit.mn

2025.02.18 № 25/029

танай _____-ны №_____-т

Төгөл-Инвест ББСБ-ын
Гүйцэтгэх захирал Ж.Баярмаа танаа

Аудиторын тайлан хүргүүлэх тухай

Бид танай компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэн, Хараат бус аудиторын тайланг хүргүүлж байна.

Бид энэхүү аудитыг Аудитын Олон Улсын Стандарт, Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Аудитын тухай хууль, Сангийн сайдын баталсан заавар журмыг удирдлага болгон гүйцэтгэсэн ба танай компаниас ирүүлсэн санхүүгийн тайланд тулгуурласан болно.

Бидэнд шаардлагатай баримт материалыг бэлтгэн өгч, хамтран ажилласан тус компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад талархаж байгаагаа илэрхийлье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ҮҮРИЙНТУЯА

ҮННТ АУДИТ ХХК
9021100248
6698824 ... 5T16494

ҮННТ АУДИТ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
17-р хороо, Ворлд Монголиа Тауэр, 615 тоот
Утас: 976-99183655, 976-80183655
И-мэйл: info@unnt-audit.mn

2025.02.18 № 25/030

танай _____-ны №_____-т

ТӨГӨЛ ИНВЕСТ ББСБ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.БАЯРМАА ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Санал дүгнэлт

Бид Төгөл инвест ББСБ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болсон жилийн Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудитыг хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, Төгөл инвест ББСБ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС"), түүнд нийцүүлэн батлагдсан журам, зааврын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын зөвлөл ("НБЁЗОУСЗ")-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус байсан ба НБЁЗОУСЗ-ийн дүрэм, эдгээр ёс зүйн шаардлагуудын дагуу ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Санхүүгийн тайланд Удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан холбогдох журам зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэх, толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан ба алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг, хариуцлага байна.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголтгүй байхаас бусад тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг, хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.
АОУС-ын дагуу аудитын туршид бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Мөн бид

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж үнэлэн, уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүссэн материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаатай дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл болон удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компани тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулга бүхий санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцсан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасан хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ҮНЭТ АУДИТ ХХК
9021100348
6698824 СБТ16494

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ҮҮРИЙНТУЯА

Санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	12/31/2023	12/31/2024
ХӨРӨНГӨ			
Санхүүгийн хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1	44,084,177.00	45,211,532.42
Зээл (цэвэр дүнгээр)	2	2,808,025,572.06	3,699,163,119.55
Бусад санхүүгийн хөрөнгө	3	137,188,309.05	195,624,093.26
Санхүүгийн хөрөнгийн дүн		**2,989,298,058.11**	**3,939,998,745.23**
Санхүүгийн бус хөрөнгө			
Татварын авлага	4	46,842,333.46	92,208,581.52
Үндсэн хөрөнгө	5	11,601,657.56	10,895,355.22
Биет бус хөрөнгө	6	440,000.00	110,000.00
Санхүүгийн бус хөрөнгийн дүн		**58,883,991.02**	**103,213,936.74**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**3,048,182,049.13**	**4,043,212,681.97**
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Бусад өр төлбөр	7	54,351,287.26	107,539,169.34
Өр төлбөрийн дүн		**54,351,287.26**	**107,539,169.34**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	8	2,515,240,000.00	2,515,240,000.00
Хуримтлагдсан ашиг, алдагдал		478,590,761.82	1,420,433,512.61
Өөрийн хөрөнгийн дүн		**2,993,830,761.82**	**3,935,673,512.61**
ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		**3,048,182,049.08**	**4,043,212,681.95**

Орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	2023	2024
Хүүгийн орлого	9	739,148,431.82	1,073,565,349.13
Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		**739,148,431.82**	**1,073,565,349.13**
Хүүгийн бус орлого	10	3,818,353.57	-
Хүүгийн бус зардал	11	184,853,032.26	149,758,163.92
Цэвэр хүүгийн бус зардал		**(181,034,678.69)**	**(149,758,163.92)**
Эрсдлийн сангийн зардал	12	70,320,202.93	141,777,154.43
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ		**487,793,550.20**	**782,030,030.78**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	13	-	242,682,420.64
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	14	39,859,651.00	6,592,890.00
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ		**447,933,899.20**	**1,018,119,561.42**
Ердийн бус орлого	14	33,206,094.46	-
Ердийн бус зардал	15	-	-
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ		**481,139,993.66**	**1,018,119,561.42**
Орлогын татварын зардал	16	5,257,551.64	10,262,663.63
ЦЭВЭР АШИГ		**475,882,442.02**	**1,007,856,897.79**

Өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	**1,915,000,000.00**	**669,648,319.80**	**2,584,648,319.80**
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	**-**
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	**-**
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	**-**
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	-	-	**-**
Тайлант үеийн цэвэр ашиг:	-	475,882,442.02	**475,882,442.02**
Хуваарилсан ногдол ашиг	-	666,940,000.00	**666,940,000.00**
Хувьцаат капиталын өсөлт	600,240,000.00	-	**600,240,000.00**
2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	**2,515,240,000.00**	**478,590,761.82**	**2,993,830,761.82**
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	**-**
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/бууралт	-	-	**-**
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	**-**
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз, гарз	-	-	**-**
Тайлант үеийн цэвэр ашиг:	-	1,007,856,897.79	**1,007,856,897.79**
Хуваарилсан ногдол ашиг	-	66,014,147.00	**66,014,147.00**
Хувьцаат капиталын өсөлт	-	-	**-**
2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	**2,515,240,000.00**	**1,420,433,512.61**	**3,935,673,512.61**

Мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2023	2024
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн:	**(103,121,762.2)**	**1,127,355.42**
Мөнгөн орлогын дүн	**3,243,233,478.84**	**3,528,845,211.97**
Зээлийн хүүгийн орлого	738,619,952.75	1,088,398,901.69
Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого	528,479.07	172,656.79
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	3,817,560.62	-
Бусад үйлчилгээний орлого	2,500,267,486.40	2,440,273,653.49
Мөнгөн зарлагын дүн	**3,346,355,241.04**	**3,527,717,856.55**
Үндсэн ба нэмэгдэл цалин	61,516,980.83	78,002,011.00
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	25,396,726.30	22,951,414.00
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	16,200,000.00	-
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	4,879,176.24	8,486,708.67
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	2,243,944.00	1,343,460.00
Татвар, даатгалын төлсөн мөнгө	123,292,253.91	61,953,931.00
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	2,428,200.00	325,000.00
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө	6,398,337.00	8,446,109.79
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	980,000.00	2,200,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	4,700,000.00	2,700,000.00
Ногдол ашгаар олгосон мөнгө	4,500,000.00	59,418,732.00
Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн бусад мөнгө	-	3,268,295,000.00
Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө	3,093,819,622.76	13,595,490.09
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн:	**26,249,295.20**	**-**
Мөнгөн орлогын дүн	**44,808,946.20**	**-**
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Бусад	44,808,946.20	-
Мөнгөн зарлагын дүн	**18,559,651.00**	**-**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	1,659,561.00	-
Торгуулийн зардал	-	-
Бусад	16,900,090.00	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(76,872,467.00)**	**1,127,355.42**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	120,956,644.00	44,084,177.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,084,177.00	45,211,532.42

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Санхүүгийн тайлан бэлтгэж тайлагнасан үндэслэл

Тайлант оны санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэж тайлагнасан. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйл. Санхүүгийн тайлангийн жил, санхүүгийн тайлан гаргах хугацаа 10.1 Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно. 10.3. Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь эхний хагас жилийн санхүүгийн тайланг 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор харилцагч санхүүгийн байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.” заалт болон 14 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэл хөтлөх 14.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагын төлөөний газар нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.” заалтуудад тус тус үндэслэн жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэсэн. Мөн тус хуулийн 8 дугаар зүйл. Санхүүгийн тайлан 8.1. Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:

8.1.1. санхүүгийн байдлын тайлан

8.1.2. орлогын дэлгэрэнгүй тайлан

8.1.3. өмчийн өөрчлөлтийн тайлан

8.1.4. мөнгөн гүйлгээний тайлан

8.1.5. санхүүгийн тайлангийн тодруулга гэж заасны дагуу дээрхи санхүүгийн тайлангуудыг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргаж тайлагнасан.

Компанийн удирдлага санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болох дараах баталгааг ирүүлсэн. Үүнд:

- Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан.
- Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн.
- Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан.
- Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй.
- Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан.
- Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Үүрэг, хариуцлага

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн удирдлага, зохион байгуулалт 18.1. “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.” гэж заасны дагуу тус байгууллагын удирдлага болон ерөнхий нягтлан бодогч нь санхүүгийн тайлантай холбоотой үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Мөн уг хуулийн 19 дүгээр зүйл. Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт 19.1. “Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж

ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно. 19.2. Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх үүрэгтэй аж ахуйн нэгж, байгууллага нь дотоод аудитын нэгжтэй байж болно.” заалтуудын дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлнэ.

Ерөнхий зарчмууд

Санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмыг баримтална. Үүнд:

- Санхүүгийн тайланг СТОУС-ын шаардлагад нийцүүлэн гаргахын тулд аж ахуйн нэгжийн удирдлага **нягтлан бодох бүртгэлийн бодлогыг** боловсруулан мөрдөх
- Аж ахуйн нэгжийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд санхүүгийн тайланг **тасралтгүй байх** зарчмаар гаргах
- Санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн **аккруэл сууриар** бэлтгэх
- Санхүүгийн тайлан дахь толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед **тогтвортой** хадгалах
- Санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад байгууллагын санхүүгийн тайлантай **зэрэгцүүлэх боломжтой** байх
- Санхүүгийн тайланд материаллаг зүйлсийг тусад нь толилуулах
- Санхүүгийн тайлангууд нь хоёрдмол утга санаа агуулаагүй, энгийн **ойлгомжтой** илэрхийлэгдсэн байх
- Санхүүгийн тайланд санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг **үнэн зөв** толилуулдаг байх
- Санхүүгийн тайлагналын олон улсын холбогдох стандартаар цэвэр дүнг гаргахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд аж ахуйн нэгж хөрөнгө, өр төлбөр эсвэл орлого, зардлыг цэвэр дүнгээр гаргахгүй байх.

Тайлагнал, толилуулгын валют

Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн **7 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн хэл ба бүртгэлийн валют 7.1 “***Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага...нь нягтлан бодох бүртгэлээ монгол хэлээр хөтөлнө. 7.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага ажил, гүйлгээгээ үндэсний мөнгөн тэмдэгтээр бүртгэж, тайлагнана.”* заалтын дагуу нягтлан бодох бүртгэлээ монгол хэл, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг, мөнгөөр бүртгэж тайлагнасан.

Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

1. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайлагналын өдрөөрх Монгол банкны ханшаар хөрвүүлэн бүртгэнэ.

2. Зээл

Зээл гэж банк, эрх бүхий хуулийн этгээдээс гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлөөр бусад этгээдэд хүүтэй буюу хүүгүй

Зээл нь эргэн төлөгдөхөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах нөөцийг хассан цэвэр дүнгээр илэрхийлэгдсэн. Зээлийн хүүний хувь хэмжээг Монголбанкны хүүгийн бодлого, ББСБ-ын активаас олох орлого болон пассивт төлөх төлбөрийн дундаж хувь хэмжээ, үйл

ажиллагааны зардал зэрэгтэй уялдуулан мөнгөн зээлийн дээд хэмжээ 4.5 хувиар тогтоохоор зээлийн үйл ажиллагааг зохицуулах журамд заасан байна.

3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

4. Бусад санхүүгийн хөрөнгө

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх зээл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

5. Урьдчилж төлсөн зардал/тооцоо

Төлбөрийг нь урьдчилж төлсөн зардлыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулж, урьдчилж төлсөн зардал гэж бүртгэн тайлант үед тохируулах бичилтээр холбогдох зардалд нь шингээнэ. Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

6. Үндсэн хөрөнгө

Нэгээс дээш тайлант хугацаанд үйлдвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, бусдад түрээслүүлэх эсхүл захиргааны зориулалтаар ашиглаж байгаа биет хөрөнгө үндсэн хөрөнгөнд хамаарна. Үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан элэгдэл, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дансны цэвэр дүнгээр нь толилуулна.

НББОУС 16 Үндсэн хөрөнгө-д заасны дагуу үндсэн хөрөнгийг анхны удаа өртгөөр нь, дараагийн тайлант үед өртгийн загвар эсхүл дахин үнэлгээний загварын аль нэгийг ашиглан бүртгэнэ.

Үндсэн хөрөнгийн элэгдэл-Үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон буюу ашиглах нөхцөл хангагдсан үеэс эхлэн элэгдлийг шулуун шугамын аргаар элэгдүүлэн сонгосон аргыг тайлант үед тогтвортой мөрдөнө. Тайлант үе бүрийн элэгдлийн зардлыг хүлээн зөвшөөч үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн дүнг санхүүгийн тайланд тодруулна.

7. Цалингийн өглөг

Ажилчдад өгөх цалин, бусад хэлбэрийн хөдөлмөрийн хөлсний өр төлбөрийн дүн хамаарна.

8. Татварын өр

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ), онцгой албан татвар (ОАТ)-ын өр, бусад татвар, төлбөр, хураамжийн тайлант хугацааны эцэст төлөгдөөгүй үлдэгдэл хамаарна. Улирал ба жилийн эцэс дэх төлөгдөөгүй татварын үлдэгдэл нь татварын байгууллагаас баталгаажуулсан үлдэгдэлтэй тэнцүү байна.

9. Хувь нийлүүлсэн хөрөнгө

Өмч нь хувь нийлүүлсэн хөрөнгө /энгийн хувьцаа/, хуримтлагдсан ашиг, алдагдал гэсэн хөрөнгөөс бүрдэнэ.

10. Хүүгийн орлого, зардал

Хүүгийн орлого ба зардлыг хуримтлуулан бүртгэж хөрөнгийн үр ашигт өгөөжийг харгалзан орлогын тайланд хүлээн зөвшөөрдөг. Үндсэн зээл эсвэл хүү эргэн төлөгдөлт нь эргэлзээтэй болсон үед хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрөхийг хойшлуулдаг. Монголбанкны шаардлагын дагуу хүүгийн төлбөр нь 90 хоногоор хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоодог.

Хүүг хүлээн зөвшөөрөхийг зогсоосон үед холбогдох хүүгийн авлагыг данснаас хасч балансын гадуур бүртгэдэг. Хүүг хүлээн зөвшөөрсөнийг зогсоосноос хойш хүүг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрдөг. Эргэн төлөгдөх эргэлзээтэй байдал арилсан нөхцөлд хүүгийн орлогыг аккурэл сууриар хүлээн зөвшөөрдөг.

11. Шимтгэл, хураамжийн орлого

Хураамж шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлыөр юм. Хураамж шимтгэлийн орлогыг тухайн зээлийг олгосон үед хүлээн зөвшөөрнө.

12. Үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардлыг нийт дүнгээр нь толилуулна. Үйл ажиллагааны зардлыг ажиллагсдын цалингийн, нийгмийн даатгал шимтгэлийн, албан татвар, төлбөр, хураамжийн, томилолтын, бичиг хэргийн, шуудан холбооны, мэргэжлийн үйлчилгээний, сургалтын, сонин сэтгүүл захиалгын, даатгалын, цахилгаан, ус, дулаан зэрэг ашиглалтын, засварын, элэгдэл хорогдлын, түрээсийн, харуул хамгааллын, цэвэрлэгээ үйлчилгээний, тээврийн, шатахууны, хүлээн авалтын зардлууд болон бусад гэж тодруулна.

13. Үйл ажиллагааны бус зардал

Үндсэн үйл ажиллагааны зардлын ангилалд ороогүй бусад зардлууд болох торгуулийн зардал, баяр ёслолын болон бусад зардал орно.

14. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)

Гадаад валютаар илэрхийлэгдсэн өр, авлага, төлөгдөөгүй зээл, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийгдсэн ханшийн тэгшитгэлийн олз (гарз), зарим мөнгөн бус зүйлсийн валютын ханшийн зөрүүний ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрсөн олз (гарз)-ыг хамруулна. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)-ыг НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө* – ийндагуу бүртгэнэ.

15. Орлогын татварын зардал

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татварын зардал болон хойшлогдсон татварын зардлаас бүрдэнэ. Тайлант үеийн татварын зардал гэдэгт нийтлэг болон тусгай хувь хэмжээгээр ногдуулсан ААНОАТ-ын нийт дүн орно.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

(төгрөгөөр)

1 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Үзүүлэлт	Дансны дугаар	12/31/2023		12/31/2024	
		Валютаар	Төгрөгөөр	Валютаар	Төгрөгөөр
Касс дахь мөнгө		-	811,448.48	-	-
Төрийн банк	106700084251	-	12,387,800.00	-	912,800.00
Төрийн банк	106700087753	-	1,317,153.47	-	10,000.00
Хаан банк	5011352159	-	18,539,520.22	-	29,424,744.65
Хаан банк /AUD/	5173201523	-	46,930.57	9.31	19,808.89
ХХБ	419003276	-	2,585,861.26	-	13,206,135.28
Голомт банк	2715156663	-	8,395,463.00	-	1,560,838.96
Нийт дүн		**-**	**44,084,177.00**	**9.31**	**45,134,327.78**

2 Зээл (цэвэр дүнгээр)

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Хэвийн зээл	2,762,980,705.77	3,408,264,815.71
Хугацаа хэтэрсэн зээл	-	152,233,227.66
Чанаргүй зээл	**195,518,691.20**	**226,022,698.14**
-Хэвийн бус		43,086,634.30
- Эргэлзээтэй	60,813,413.20	91,224,351.23
- Муу	134,705,278.00	91,711,712.61
Зээлийн эрсдэлийн сан	150,473,824.91	87,357,621.96
Нийт зээл	**2,958,499,396.97**	**3,786,520,741.51**

3 Бусад санхүүгийн хөрөнгө

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Тэмдэгтийн хураамжийн авлага	874,390.00	1,466,628.89
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн	131,813,919.05	211,638,551.49
(Найдваргүй авлагын нөөц)	(309,505.21)	(309,505.21)
(Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн сан)	-	(17,171,581.91)
Бусад	4,809,505.21	-
Нийт дүн	**137,188,309.05**	**195,624,093.26**

4 Татварын авлага

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Татварын авлага	46,842,333.46	92,208,581.52
Нийт дүн	**46,842,333.46**	**92,208,581.52**

5 Үндсэн хөрөнгө

Үзүүлэлт	Тавилга Эд хогшил	Комьпютер, дагалдах хэрэгсэл	Бүгд
Эхний үлдэгдэл	**10,498,600.00**	**5,424,800.00**	**15,923,400.00**
Нэмэгдсэн:	2,207,000.00	**-**	**2,207,000.00**
Худалдан авсан	2,207,000.00	**-**	**2,207,000.00**
Үнэ төлбөргүй авсан	-	**-**	**-**
Хасагдсан	-	**-**	**-**
Худалдсан	-	**-**	**-**
Акталж, устгасан	-	**-**	**-**
Үнэгүй шилжүүлсэн	-	**-**	**-**
Эцсийн үлдэгдэл	**12,705,600.00**	**5,424,800.00**	**18,130,400.00**
Хуримтлагдсан элэгдэл	-	-	**-**
Эхний үлдэгдэл	**2,212,097.00**	**2,109,645.44**	**4,321,742.44**
Тайлант жилд байгуулсан	1,105,034.30	1,808,268.04	**2,913,302.34**
Хасагдсан	-	-	**-**
Эцсийн үлдэгдэл	**3,317,131.30**	**3,917,913.48**	**7,235,044.78**

6 Биет бус хөрөнгө

Үзүүлэлт	Программ хангамж	Бусад	Бүгд
Эхний үлдэгдэл	**3,300,000.00**	**-**	**3,300,000.00**
Худалдан авсан	-	-	-
Үнэ төлбөргүй авсан	-	-	-
Хасагдсан	-	-	-
Худалдсан	-	-	-
Акталж, устгасан	-	-	-
Үнэгүй шилжүүлсэн	-	-	-
Эцсийн үлдэгдэл	**3,300,000.00**	**-**	**3,300,000.00**
Хуримтлагдсан элэгдэл			
Эхний үлдэгдэл	**2,860,000.00**	**-**	**2,860,000.00**
Тайлант жилд байгуулсан	330,000.00	-	330,000.00
Хасагдсан	-	-	-
Эцсийн үлдэгдэл	**3,190,000.00**	**-**	**3,190,000.00**

7 Бусад өр төлбөр

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Ногдол ашгийн өглөг	6,000.00	6,000.00
ХХОАТ-ын өглөг	2,298,249.92	5,079,189.88
Орлогын албан татварын өглөг	52,047,037.34	102,453,979.46
Нийт дүн	**54,351,287.26**	**107,539,169.34**
	-	-

8 Хувь нийлүүлсэн хөрөнгө

Үзүүлэлт	12/31/2023	12/31/2024
Энгийн хувьцаа	2,515,240,000.00	2,515,240,000.00
Нийт дүн	**2,515,240,000.00**	**2,515,240,000.00**

9 Хүүгийн орлого

Үзүүлэлт	2023	2024
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	738,619,952.75	1,073,392,692.34
Харилцах дансны хүүгийн орлого	528,479.07	172,656.79
Нийт дүн	**738,619,952.75**	**1,073,392,692.34**

10 Хүүгийн бус орлого

Үзүүлэлт	2023	2024
Гадаад валютын арилжааны орлого	792.95	-
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	3,817,560.62	-
Нийт дүн	**3,818,353.57**	**-**

11 Хүүгийн бус зардал

Үзүүлэлт	2023	2024
Үндсэн болон нэмэгдэл цалин	106,536,769.10	97,322,749.00
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	13,231,047.00	12,095,344.00
Бусад	35,500.00	
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	6,398,337.00	8,446,109.82
Аудитын төлбөр, мэргэжлийн үйлчилгээ	980,000.00	2,200,000.00
Түрээс	16,200,000.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	3,131,696.67	3,243,302.34
Харилцаа холбоо, интернет	2,258,909.24	4,672,454.67
Шатахуун болон тээврийн зардал	2,620,267.00	3,339,254.00
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ		475,000.00
Зохицуулалтын хураамжийн зардал	4,700,000.00	2,700,000.00
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	4,103,000.00	10,648,000.00
Зар сурталчилгаа, маркетингийн судалгаа	2,428,200.00	325,000.00
Бичиг хэргийн зардал	1,848,381.00	1,123,460.00
Ариун цэврийн зардал	395,563.00	220,000.00
Бусад	19,985,362.25	2,947,490.09
Нийт дүн	**184,853,032.26**	**149,758,163.92**
	-	-

12 Эрсдлийн сангийн зардал

Үзүүлэлт	2023	2024
Зээлийн эрсдэлийн зардал	-	141,777,154.43
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгийн эрсдэлийн зардал	70,320,202.93	-
Нийт дүн	**70,320,202.93**	**141,777,154.43**

13 Үндсэн бус үйл ажиллагааны орлого

Үзүүлэлт	2023	2024
Бусад орлого	-	242,682,420.64
Нийт дүн	**-**	**242,682,420.64**

14 Үндсэн бус үйл ажиллагааны зардал

Үзүүлэлт	2023	2024
Торгуулийн зардал	-	5,000,000.00
Баяр ёслол	1,659,561.00	1,363,290.00
Бусад	38,200,090.00	229,600.00
Нийт дүн	**39,859,651.00**	**6,592,890.00**
	-	-

15 Ердийн бус орлого

Үзүүлэлт	2023	2024
Ердийн бус орлого	33,206,094.46	-
Нийт дүн	**33,206,094.46**	**-**

16 Орлогын татварын зардал

Үзүүлэлт	2023	2024
Орлогын татварын зардал	5,257,551.64	10,262,663.63
Нийт дүн	**5,257,551.64**	**10,262,663.63**